

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Чүлтэмийн Лувсанжамбаа	Дугаар	L290
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Тариалан сум
Төрсөн газар	Тариалан сум	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хоолтын эхний дуган, Ховшихын амны дуган	Сүм хийдийн дугаар	ХӨТР 058, ХӨТР 059
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын19	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Тариалан сумын Хоолтын эхний дуган, Ховшихын амны дуган

Мөнхбат: Тэгэхээр Чүлтэмийн Лувсанжамбаа гэдэг энэ өндөр буурал дээдсээс Хөвсгөл аймгийн Тариалан сумын нутаг Давааны ар баг буюу тухайн үеийн Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны Гөрөөчин овог отгийнхны одоо эзэмшил нутагт байсан буддын шашны гурван ч дуганы тухай сургийг сонсоод манай судалгааны багийнхан бас одоо хэдийгээр академич Ренчин гуйн жагсаалтанд ороогүй ч гэсэн шинээр олдсон мэдээлэл гэж үзээд энэ тухай ярилцлагыг өрнүүлсэн юм аа.Тэгэхээр та энэ одоо Хөвсгөл аймгийн Тариалан сум буюу одоогийн, тухайн үеийн Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны одоо хойд хязгаар болох Давааны ар багийн нутгийн хүн юм байна аа.Тэгэхээр бид нартай ингээд өрнүүлсэн ярианы явцад та бид нарын судалгааны жагсаалтанд ороогүй байгаа тэр давааны ард байдаг Ховшихын амны дуган, за мөн Хоолтын эхний дуган, мөн Цагаан-Уулын овооны урд байдаг нэг дуган ингээд буддын шашны гурван ч дуган хурал номын газрын тухай одоо товчхон мэдээлж байна. Тэгэхээр энэ тухайгаа та одоо манай судалгааны багт хувь нэмэр оруулах үүднээс үнэтэй мэдээлэл өгөх үүднээс ингээд одоо улам дэлгэрэнгүй ярьж өгнө үү гэж танаас хүсч

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байна аа. Тэгэхээр эхлээд Лувсанжамбаа гуай, хоёулаа Ховшихын амнаас эхлэх үү, за тэгье. Тэгэхээр Ховшихын ам гэдэг маань одоо Хөвсгөл аймгийн ямар багийн нутагт байна, ямар ямар одоо...?

Лувсанжамбаа: Би есөн настай байхдаа Ховшихын амны дуган гүнриг хурдаг тийм газар байлаа. Есөн настай байхдаа тэнд очиж би сууж байсан юм аа. Аа тэр жилдээ нэг хурдаг хурал. Бөөрөлжийн хүрээнээс очиж тэнд сууж хүрж байсан лам нарууд аа. Ховшихт өсөж төрсөн Ховшихын Тэхүүн лам гэж Гончиг гэлэн гэдэг хүн жилийн нэг хуралд гэсгүйгээр суудаг байсан юм.

Мөнхбат: Бөөрөлжийн хүрээ гэдэг чинь одоо Гөрөөчний хүрээг хэлж байгаа тийм ээ?

Лувсанжамбаа: Гөрөөчний хүрээ, тийм.

Мөнхбат: Тэгэхээр жилдээ нэг хурдаг байсан гэхээр одоо цагийн хуралтай байжээ?

Лувсанжамбаа: Тийм ээ тийм. Яг үнэн.

Мөнхбат: Нэг л дуган байсан уу, ерөөсөө?

Лувсанжамбаа: Ганцхан дуган байсан юм. Тэрүүний тэр чинь нэг хурчихаад л тардаг, тийм цавтай манжтай байсан.

Мөнхбат: Өө бас цавтай манжтай?

Лувсанжамбаа: Тийм, цавтай манжтай байсан юм байгаа юм. Тэрүүний сахиул нь Аагаа лам гэж байсан юм.

Мөнхбат: Одоо байнгын тэндээ байдаг?

Лувсанжамбаа: Тийм, байнгын тэндээ сахиж байдаг.

Мөнхбат: Бурхан тахилыг нь бас одоо ингээд л арц хүжийг нь асаагаад л?

Лувсанжамбаа: Тийм тийм. Тийм лам байсан юм, Аагаа лам гэж. Аагаа ламын хүрээг нэг удаа нэг талсан юм байгаа юм. Тэр тэгээд одоо энэ Булган аймгийн харъяанаас явж байсан хоёр хүн хүрч ирж...

Мөнхбат: Хоёр хүн хүрч ирж...?

Лувсанжамбаа: Хоёр хүн хүрч ирж тэр Аагаа ламын хүрээг талаад ганц буурал моринд нь, доторх мөнгө тахил хэрэглэлүүдийг нь аяаад явчихсан юм. Тэгээд одоо энэ Булган аймгийн Гачаа лам гэж одоо манай Гөрөөчөөс залагдсан лам. Баяннамдагийн хүү Гачаа лам гэдэг тэр лам Булган аймагт залагдсан юм. Тэр

Булган аймагт залагдаад оччихсон байж байхад нь манай эндээс тэр Гачаа ламд мөргөх гэж хоёр хүн очсон байсан юм байна лээ. Тэр хоёр хүн эргэж буцаж явахдаа тэр хулгай хийсэн хоёр хүнтэй тааралдсан. Тэр хийдийн буурал номонд юмыг нь аччихсан, дуганыг нь юмыг аччихсан явж байхыг замдаа барьж аваад тэгээд морийг нь хөтлөөд юмыг нь авчраад өгчихсөн. Тэгээд тэр Аагаа ламыг хүн оролдохгүй юу. За хүрээний юмыг талуулчихаад та одоо юу бодож байна, одоо яах гэж бодож байна гэсэн аа яахав дээ авчраад өгчихнө биз дээ гэж байсан гэж нэг тийм одоогоор байна уу бас тийм юм байдаг юм. Тэгээд авчирч өгсөн. Тэрнээс хойш л гар хөндөгдөөгүй байж байгаад л энэ хэлмэгдлийн үед л байхгүй болсон дуган даа, тэр одоо.

Мөнхбат: Тэгэхээр таны ярианаас үзэхэд түр цагийн хуралтай байсан тэр Ховшихын амны дуган бол үндсэндээ энэ Гөрөөчний хүрээний салбар л байж дээ, тийм ээ?

Лувсанжамбаа: Ер нь тэгж л таарна ш дээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Гөрөөчний хүрэнээс л салбарлаж гарсан тийм ээ?

Лувсанжамбаа: Гөрөөчний хүрэнээс л салбарлаж гарсан одоо тэр Цагаан-Уулын дуган ч гэсэн Гөрөөчний хүрэнээс л...

Мөнхбат: Тэгэхээр энэ юу одоогийн Хөвсгөл аймгийн Тариалан сумын төвөөс баруун хойд чиглэлд одоо энэ яг Ховшихын ам хүртэл хэд орчим км байдаг бол?

Лувсанжамбаа: Тариалан сумын төвөөсөө дөчин хоёр км байдаг юм.

Мөнхбат: Таны тэр ярьж байгаа Бөөрөлжүүтийн буюу Гөрөөчний хүрээний тууриас хэд орчим км байх бол?

Лувсанжамбаа: Бөөрөлжийн хүрээ чинь Тариалан сумын төвөөсөө арван найман км байна уу.

Мөнхбат: Тэгэхээр дөчин хоёроосоо арван наймыг хасна л гэсэн үг шүү дээ, тийм ээ?

Лувсанжамбаа: Тийм тийм.

Мөнхбат: Тэгэхээр дөчин хоёроос арван наймыг хасахаар хорин дөрвөн км болж байна.

Лувсанжамбаа: Тийм.

Мөнхбат: Тэгвэл одоо яг Гөрөөчний хүрэнээсээ хорин дөрвөн км яваад л тэр Ховшихын амны дуганд хүрэх ийм зайтай байжээ. Тэгэхээр энэ Ховшихын амын дуган ер нь яаж мөхсөн бол, бурхан тахилыг нь мэдээж 37, 38, 39 онд л эзгүйрээ биз, тэгээд тэрнээс хойш шаачихсан юм болов уу тэр дор нь, эсвэл тодорхой хэмжээгээр байж байгаад дөч тавиад оны нүүрийг үзсэн юм болов уу?

Лувсанжамбаа: Ер нь тэгээд л гэв гэнэтхэн алга болчихсон юм.

Мөнхбат: Одоо буулгаад л нураачихсан?

Лувсанжамбаа: Тийм ээ, буулгаад л нураачихсан.

Мөнхбат: За тэгвэл хоёулаа одоо хоёр дахь дуганыхаа тухай ярилцая. За энэ бол одоо Хоолтын эхний дуган.

Лувсанжамбаа: Цагаан овооны урд дэвсэг дээр дуганы суурь байгаа.

Мөнхбат: Хоолтын эх, Цагаан-Уулын овооны урд дэвсэг дээр?

Лувсанжамбаа: Дуганы ор байгаа.

Мөнхбат: За энэ мөн бас Тариалан сумын нутаг Давааны ар гэдэг газар орж байна тийм ээ. Энэ Тариалан сумын төвөөс аль чигт хэд орчим км байна, мөн л баруун хойшоо?

Лувсанжамбаа: Тэр Ховшихын чинь дуганаас дээшээгээ арван км.

Мөнхбат: Дээшээгээ арван км?

Лувсанжамбаа: Тийм, Ховшихын дуганаас дээш эхэндээ гарсан, арван км.

Мөнхбат: Одоо энэ хоёр дуган хоорондоо их ойрхон байж тийм ээ, арван км гайгүй?

Лувсанжамбаа: Тийм, ойрхон.

Мөнхбат: Аа сумынхаа төвөөс бол нэг тавь гаран км болж байна тийм ээ?

Лувсанжамбаа: Дөчин хоёр байлуу...

Мөнхбат: Тийм, өмнө нь дөчин хоёр гэж хэлсэн. Мотоциклтэй явж байхад дөчин хоёр гэж үзэж байсан юм. Одоо сайн мэдэхгүй байна аа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Тэгэхээр Хоолтын эхний энэ Цагаан-Уулын овооны урдах энэ дуган ер нь мөн л одоо ямар хуралтай байсан юм, хаанаас лам нар ирж одоо хурал ном хурдаг байсан юм, тэр зод лүйжин тавьдаг гэж та нэг түрүүн хэлж байсан. Тэгэхээр энэ зод лүйжин гэж яаж яаж, ямар улсууд яах одоо ямар зорилгоор тавьдаг байсан юм бол оо?

Лувсанжамбаа: Аа би тэрний чинь тухай хэлээд өгчихөө. Тэр Цагаан-Уулын тэр дээр байгаа дуганыг Тавдайжамба гэдэг хүн барьсан дуган. Аа тэрүүнийг үст лам Дамдин цорж гэдэг хүн бариулсан юм. Аа тэгээд тэнд зод лүйжин тавьдаг. Зод лүйжин тавина гэдэг маань нярз даяан хийдэг одоо энэ булаг. Булагт долоон хоног суусан, хүүр оршуулгын газар долоон хоног суусан иймэрхүү юман дээр очиж байсан тийм улсууд хурдаг тийм хурал байсан юм. Тэр маань яадаг вэ гэхлээр дандаа ийм хүүр оршуулгын газрын юмыг одоо юу гэдэг юм бэ дээ, одоо тонилгодог ухаантай, тийм юм байсан юм. Тэр яадаг вэ гэхлээр хонх дамар л хоёртой. Тэрнээс хэнгэрэг бүрээ бишгүүр байдаггүй. Хонх дамар л хоёртой, тийм дуган дээр хурж байсан юм аа. Тэгээд тэрүүнийг бол анхлан хурж байхад нь бол ерөөсөө тэр их нарийн. Тэрүүнийг нарийндаа юу байдаг юм гэхлээр зэрэг хүн болгон тэрүүнийг тэгж хурдаггүй, заавал лүн бан авч байж хурдаг.

Мөнхбат: Лүн бан гэдэг чинь одоо юу билээ?

Лувсанжамбаа: Одоо увидас, багшийн барилдлагаа хийдэг. Одоо тийм юм байдаг шүү дээ, энэ хүн л сайн мэдэх байх. Багшийн барилдлагаа гэдэг чинь. Тэгж хурж байсан юм. Тэд тэр одоо Дамдин цорж гэдэг хүн л одоо анхлан хурж эхэлсэн. Тэрнээс хойш хойноосоо энэ Унгиа талаасаа Имшийн Нямаа гэдэг хүн ирж байлаа. Энэ Булган аймаг талаас Дангаа гэдэг хүн ирж байлаа. Дэгжиндэмбэрэл гэдэг хүн ирж байлаа. Манай эцэг доголон Чүлтэм гэдэг хүн сүүж байлаа. Хэн... өө мондь гэж, Догоонаюуш гэж Улаанбаатар хотод лүйжин тавьж байгаад сүүлд өнгөрлөө дөө, энэ ардчилал үүссэнээс хойш. Гомбо-Очир гэдэг хүн бас байлаа. Эд нар хурж байсан юм аа. Тэгэхдээ тэр чинь их нарийн л даа. Хандмаагийн хорлол болно гэж тэр увидас лүн бан аваагүй хүн бол хурдаггүй юм. Тэр яадаг вэ гэхлээр одоо галзуурч магадгүй гэж тийм нарийн утгатай хурал хурж байсан юм даа.

Мөнхбат: Тэгэхээр энэ хоолтын эхний энэ Цагаан-Уулын овооны урд байгаа энэ дуганы туурийг одоо тэр тойроод байдаг уул овоо усны нэрийг одоо та санаж байвал хэлэхгүй юу, тийм ээ?

Лувсанжамбаа: Тэрнийг би нутгийн хүн андахгүй л дээ. Тэр Ар хөндий гэж нэрлэдэг юм, тэр баруун талын нь нэг хөндийг. Ар хөндий гэж нэрлэдэг юм. Урд талынх нь уулыг Нармандал гэдэг юм. Хоолтын тэрнийхээ дээшхийг нь Соёо гэж нэрлэдэг юм. Тэрний баруун талынхыг нь Малзан гэж нэрлэдэг юм. Малзан, Соёо, Дуураг гурав болвол Дуургийн нуруунаас бууж ирсэн их том нуруунаас бууж ирсэн гурван ам байгаа юм.

Мөнхбат: Энэ Цагаан-Уулын овооны урд байгаа тэр Хоолтын эхний дуганы ойр орчимд эртний болон одоо ч гэсэн тахиж байж болох тийм орон нутгийн тахилгатай уул овоо одоо гол горхи булаг шанд тийм юм байгаа болов уу?

Лувсанжамбаа: Байгаа.

Мөнхбат: Ямар овоо байна, одоо?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Лувсанжамбаа: Одоо би сая хэллээ. Тэр Нармандал гэж уул байдаг юм.Тэр Нармандлыг одоо дээр үед, Нармандлыг тахисан хүн заавал хоолтой явна аа гэж байсан тийм домог бололтой байдаг юм. Том Цэдэн гэдэг хүн энэ Бөөрөлжийн хүрээг балраад байхгүй болж байхад нь хамгийн сүүлд үлдсэн Том Цэдэн гэдэг хүн байсан юм.Тэр Том Цэдэн гэдэг хүн долоон үеийн хоосон байсан юм байна лээ.Тэгээд Зүүгийн багшийг залж ирэхээр нь асуусан, тэгсэн танай тэр урд голын эхэнд Нармандал гэж нэг уул байгаа юм байна.За тэрнийг тахих юм бол хоолтойгоо явж үхнэ ээ гэсэн. Бүр энэ хэлмэгдэл үүссэнээс хойш юм хэцүү болж байх үед тэр Том Цэдэн гэдэг хүн, Баасан гэдэг хүнтэй очиж тахиж байхыг нь би мэднэ.Тэр үед маш их нууц байсан л даа, тэр Нармандал гэдэг уул. Тэгээд хоолтой явж байж үхсэн гэдэг юм байна лээ, хүн.

Мөнхбат: Тэгэхээр энэ Хоолтын эхний тэр Цагаан-Уулын овооны тэр дуганы сүүлчийн хувь заяа 1937, 1938 оны үед монголд явагдсан их хэлмэгдүүлэлтийн үед монголын бурхны шашны сүм хийдийн тэр хувь заяа бол энд давтагдсан байх аа., тийм ээ.Ер нь бол одоо түр цагийн хурал хаасны дараа сүм хийд эзгүйрээд хоосроод одоо дөч, тавиад оны нүүрийг үзсэн түүх бас байдаг. Эсвэл ерөөсөө 37, 38 оны үед үйл ажиллагааг нь бүрмөсөн зогсоогоод тэгээд тэр дор нь галдан шатаагаад устгачихсан бас түүх байдаг. Тэгэхээр энэ хоёр түүхийн алийг нь давтсан юм бол оо, бид хоёрын энэ дуган?

Лувсанжамбаа: Хамгийн сүүлчийнх нь.

Мөнхбат: Ерөөсөө л одоо үйл ажиллагааг нь зогсоонгуут л тэгээд л байхгүй болсон?

Лувсанжамбаа: Тийм, гучин найман онд.

Мөнхбат: Гучин найман онд тэгээд л дууссан?

Лувсанжамбаа: Тэгээд л ерөөсөө дууссан.

Мөнхбат: За ингээд таньд баярлалаа. Таны өгсөн энэ мэдээлэл монголын буддын шашны сүм хийдийн түүхэн товчоо төслийн судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулах, үнэтэй мэдээлэл болно гэдэгт итгэж байна аа. Таньд баярлалаа.